

“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 1

Рашаант

Хурал 2025 оны 4 сарын 30-ны өдрийн 14,00 цагаас компанийн хурлын танхимд эхлэв.

Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурал хуралдуулах товыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3-р сарын 12-ны өдрийн 02 тоот тогтоолоор гаргасан бөгөөд хурлын зарыг “Өнөөдөр” МН өдөр тутмын сонины 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн №045 /8109/, 4 дүгээр сарын 1-ний өдрийн №057 /8121/ дугааруудад тавьж нийтлүүлсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/366 тоотоор гаргуулсан болно.

“Талын гал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн хурлын шийдвэрээр Тооллогын комиссын даргаар компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Түвшинбаярыг, гишүүдээр компанийн бичиг хэрэг, эрүүл ахуйч эмч Б.Сайхансанаа, уулын мастер О.Цолмон нарыг тус тус томилсон болно.

Тоологын комиссын танилцуулсанаар хуралд тус компанийн нийт 694264 хувьцаа эзэмшигч, 26 хүн хуралд оролцохоос нийт 683546 хувьцаа эзэмшигч 3 хүн ирж, хурлын ирц 98,5 хувь болсон тул хурлыг 14,00 цагаас эхлүүлэв.

Тус компанийн хувьцаа эзэмшигч С.Цэрэндондовын санал болгосноор хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, хувьцаа эзэмшигч У.Батсуурь, нарийн бичгийн даргаар хувьцаа эзэмшигч С.Цэрэндондов нарыг санал нэгтгэйгээр сонгов.

Хурлын дарга У.Батсуурь “Талынгал” ХК-ийн 2025 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг хуралд оролцогчдоор хэлэлцүүлэн батлуулав. /Хурлаар хэлэлцсэн асуудлууд, хурлын дэгийг хавсаргав./

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу, хурлын дэгийн хүрээнд хэлэлцэж, урьдчилан зөвшилцөж тохиролцсоны дагуу хэлэлцсэн асуудал тус бүрээр хувьцаа эзэмшигчид саналаа чөлөөтэй илэрхийлж, хариулт авч байв.

Хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ч.Түвшинбаяр оролцсон бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар бусад гишүүдтэй ижил байр суурьтай байсан болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Болдбаатар, П.Дашпүрэв нар компанийн хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хуралд оролцоогүй болно.

Хурлаар хэлэлцсэн асуудлаар гаргах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдийн гаргасан саналыг Тооллогын комисс саналын хуудсаар авч, нэгтгэн, баталгаажуулж, Тооллогын комиссын гаргасан 01 тоот тогтоолыг комиссын дарга Ч.Түвшинбаяр танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлаас тооллогын комиссын дээрхи шийдвэрийг зөвшөөрч дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тухай тогтоол
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн боломжийн бодит байдлыг харгалзан үзэж, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах боломжгүй гэж үзэв.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгогдсоныг баталгаажуулах тухай тогтоол
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах тухай тогтоол эдгээр болно.

Хурал хэлэлцэх асуудлаа хэлэлцэж 16,30 цагт дуусав.



ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.ЦЭРЭНДОНДОВ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЯЦСАН:

ХУРЛЫН ДАРГА

У.БАТСУУРЬ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН:

Ч.Түвшинбаяр

Ч.ТҮВШИНБАЯР